

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE EARTHQUAKE DISASTER PROTECTION PLAN

Г.Батмөнх

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн магистрант, дэд хурандаа

Batmunkh.G

Graduate student at the Institute of Management Academy, the University of Internal Affairs, lieutenant colonel

*хариуцлагатай зохиогч: Batmunkh.G@gmail.com

Хураангуй. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний өнөөгийн байдлаар гамшгийн нөхцөл байдал, тэр тусмаа газар хөдлөлтийн гамшгийн үед иргэдийн эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгийг аврах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах үндэс бол харилцан ажиллагааг зөв оновчтой зохион байгуулснаар хэмжигдэнэ. Ялангуяа гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааг явуулах үед бусад хүч хэрэгслийг татан оролцуулах, тэднийг хэн удирдах, хаана байрлуулах, мэдээлэл хэрхэн дамжуулах гэх мэт харилцан ажиллагааны олон асуудлууд үүсэх бөгөөд эдгээрийг зөв оновчтой төлөвлөж харилцан ажиллагааг амжилттай зохион байгуулснаар хүч хэрэгслийг шуурхай хуваарилах, цаг хугацаа хэмнэх, хор уршгийг богино хугацаанд арилгах, хохирол багатайгаар даван туулах ач холбогдолтой билээ.

Энэхүү илтгэлээр гамшгаас хамгаалах төлөвлөгөөний түүхэн хөгжил, эрх зүйн баримт бичиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шат, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт болон Олон улсын туршлагыг харьцуулан судалж үзэхэд манай улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, загвар нь хэрэглэхэд хялбар ойлгомжтой байгаа бөгөөд энэхүү төлөвлөгөө нь бүх шатанд цаас төдий хэрэгжилт хангалтгүй гэсэн ойлголт төрж байна. Мөн гамшгийн өмнөх үе шатанд бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд бүх шатны гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиуд бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ тусгасан ч санхүүгийн асуудал тулгарч байгаа нь ихээхэн сөргөөр нөлөөлж байна. Иймд Олон улсын туршлага сургамжид үндэслэн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний оролцооны зарчмыг баримтлан гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрсдэлийг бууруулах төлөвлөлтийг тухайн орон нутгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээнд суурилсан оновчтой боловсруулахад үр дүнтэй төлөвлөгөө болно гэж үзэж байна.

Abstract. The current state of disaster management planning is that the basis for effectively organizing disaster management activities, especially in the event of an earthquake, to save the health, lives, and property of citizens, and to eliminate the consequences of a disaster, is measured by the proper and rational organization of interaction. In particular, when eliminating the consequences of a disaster and carrying out urgent reconstruction operations, many interaction issues arise, such as involving other forces, who will control them, where they will be located, how to transmit information, etc. By properly planning and successfully organizing these interactions, it is important to quickly allocate people, forces, and equipment, save time, eliminate the consequences in a short time, and overcome the damage with minimal damage.

This report compares the historical development of disaster management plans, legal documents, disaster management activity stages, disaster management plan development, and international experience. It is clear that the guidelines and models for developing our country's disaster management plans are easy to use and understand, and that this plan is not only paper-based but also insufficiently implemented at all stages. Also, in the pre-disaster phase, disaster management departments and professional units at all levels have included measures to ensure preparedness and reduce risks, but financial problems are having a significant negative impact. Therefore, based on international experience and lessons learned, it is believed that the disaster



Дотоод Хэргийн Их Сургууль



management plan, based on the participatory principle, will be an effective plan for the rational development of disaster prevention, preparedness, and risk reduction planning based on local disaster risk assessment.

Түлхүүр үг. Төлөвлөгөө, байгууллага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги.

Key words. Plans, organizations, disaster relief services, and professional classes.

Оршил. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны оновчтой, тодорхой бодлогыг боловсруулж, хөгжлийн чиг хандлага, зорилго, зорилтыг зөв тодорхойлох нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн янз бүрийн түвшинд, газар хөдлөлтийн гамшгийн ээдрээ төвөгтэй нөхцөлд гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлага, төлөвлөгөөг оновчтой явуулах боломжийг бүрдүүлдэг.

Байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, цаашдын төлөв, шинж чанарын талаар нарийвчлан судлах, гамшгийн эрсдэлийг үнэлэх, үүний үндсэн дээр болзошгүй гамшиг, осолтой тэмцэх чадавхыг дээшлүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, түүний удирдлагыг боловсронгуй болгоход чиглэсэн тодорхой бодлогыг боловсруулах хэрэгтэй.

Манай улсад сүүлийн 10 жилд тохиолдсон гамшгийн статистикаас харахад жилд дунджаар 3200 орчим аюулт үзэгдэл, осол тохиолдож, 180 гаруй хүн амь насаа алдаж, 110 орчим тэрбум төгрөгийн хохирол учирч байна.

Улаанбаатар хотын бүс нутгийн орчимд сүүлийн 10 жилийн хугацаанд магнитуд нь 3.5 болон түүнээс их хүчтэй газар хөдлөлт 13 удаа болсон байна. 2024 онд Улаанбаатар хот орчмын бүс нутагт нийт 447 удаагийн газар хөдлөлтийн чичирхийлэл болсон судалгаа гарсан. Газар хөдлөлтийн давтамж, чичирхийлэлийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь бэлэн байдлыг хангах, хэрхэн ажиллах төлөвлөгөөг урьдчилан хийх шаардлагатай болж байна.

Зорилго. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас томоохон хэмжээний цаг агаар, геологи, биологийн гаралтай аюулт үзэгдэл, ослын төрөл, тоо, давтамж жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа өнөө

үед гамшигт тэсвэртэй хот суурин, хүрээлэн буй орчныг цогцлоох, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах нөхцөл байдал зайлшгүй тулгарч байна. Иймд гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Олон улсын туршлага сургамжийг харьцуулан судалж, гамшгаас хамгаалах төлөвлөгөөг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино.

Үндсэн хэсэг /арга зүй/. Төлөвлөлт бол өнөөгийн байдлаас хүрэх гэж хүсч буй байдал хоёрыг холбогч гүүр гэж олонх судлаачид үзжээ. Тэгвэл төлөвлөгөө зохиох хариуцлагыг менежерүүд хүлээдэг. Төлөвлөлт бол аливаа байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хамгийн хэмнэлттэй ямар арга замаар хүрэх вэ гэдгийг шийдвэрлэх үйл явц юм. Харин төлөвлөгөө нь тэрхүү үйл явцыг удирдан зохион байгуулж буй субъектийн гаргасан шийдвэрүүдийг тусгасан албан ёсны баримт бичиг (Цэдэв П., 2018, хууд. 15) юм.

Мөн үүссэн нөхцөл байдалд үйл ажиллагаагааг оновчтой төлөвлөхийн тулд төлөвлөлтийн үйл явцыг сайтар судалж танин мэдэх нь зүйтэй. Тооцооны үндсэн дээр нөөцөд тулгуурлан, зорилгод уялдуулан гүйцэтгэж байгаа үйл ажиллагааны ерөнхий төлөв планыг төлөвлөлт гэж болно (Цэдэв П., 2018). Төлөвлөлтийн асуудлыг авч үзэхдээ төлөвлөлт, төлөвлөгөө гэсэн үндсэн ойлголтыг ялган ойлгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл төлөвлөлт нь цаг хугацаа, тооцоолол, бодомжийн шинж чанартай хүчин зүйл бөгөөд энэхүү бодомжийг зорилгын нэгэн адил бодит биелэгдэхүйц байдлаар тооцоолон цаасан дээр буулгасан бичиг баримтыг төлөвлөгөө гэж нэрлэнэ.

Энэ утгаараа төлөвлөгөө бол биелэгдэхүйц үйл ажиллагааг тусгасан баримт бичиг, байгууллагын үйл ажиллагааны чиглүүлэгч нь юм.

Энэ бүгдээс дүгнэн үзэхэд гамшгаас хамгаалах төлөвлөгөө гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах үйл ажиллагааг иж бүрнээр хэрэгжүүлэх бэлтгэл арга хэмжээг хэлнэ.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодлогыг тодорхойлоход анхаарах нэг гол онцлог бол газар хөдлөлийн гамшиг нь улс орныг төдийгүй бүс нутгийг, тив, дэлхийг хамарч болдгоос гадна гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь улс орны тогтвортой хөгжил, хүн амын аюулгүй байдлыг хангах нэг үндсэн нөхцөл болдог явдал юм.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний түүхэн хөгжлийг тоймлон судалж үзэхэд анх Улсын Иргэний Хамгаалалтын газарт иргэний хамгаалалт төлөвлөгөө нэртэйгээр хийгдэж байсан. Улсын иргэний хамгаалалтын Төв Штаб Улсын иргэний хамгаалалтын оперативын болон улсын алба, аймаг, хот, сум, район /одоогийн дүүрэг/, яам, тусгай газар, объектын иргэний хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах ажлыг 1976 оны сүүлийн хагасаас эхэлж, дэс дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Төв штаб эхлээд төлөвлөгөө боловсруулах заавар гаргаж улсын алба, аймаг, хотуудад хүргэсэн ба 1977 оны эхний хагаст дээрх төлөвлөгөөнүүдийг үлгэрчилсэн загвар боловсруулж штабуудад өгснөөр тэд уг төлөвлөгөөг боловсруулахад хялбар дөхөм гарын авлагатай болсон байна. Төв штаб төлөвлөгөө боловсруулах ажлыг аргазүйн болон мэргэжлийн удирдлагаар байнга хангаж, аймаг, хотын иргэний хамгаалалтын штабын дарга нар, улсын албадын мэргэжилтнүүдийн цугларалтаар тодорхой аргачилсан хичээл зааж, семинар хийж, газар дээр нь очиж биечлэн туслалцаа үзүүлж ажилласны үр дүнд 1979 оны эхний хагас гэхэд улсын 14 алба, 18 аймаг, 3 хот, нийслэлийн төвийн 4 дүүрэг, Налайх хот төлөвлөгөөгөө боловсруулан батлуулж

мөрджээ. Энэ хугацаанд 301 сум болон 50 гаруй сум эрхтэй хороо, орон нутгийн хотууд үндсэндээ төлөвлөгөөтэй болж, ийнхүү төлөвлөгөө боловсруулах ажлыг 1967 оноос эхэлсэн түүхтэй (Дамдин П, 2017, хууд. 71).

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг нарийвчлан боловсруулах, 2003 онд Гамшгаас хамгаалах тухай шинээр батлагдсан хуулийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах ерөнхий газрын даргын 2004 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 354 дүгээр тушаалаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний нийтлэг загвар, хэрэглэх зааврыг тус тус баталсан байна. Энэ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц агуулгыг тодорхойлон гаргасан байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний эрх зүйн зохицуулалтыг судлахад:

Гамшгаас хамгаалах үндэсний чадавхыг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр “Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр (2015-2025)”, “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2015-2030)” зэрэг гамшгаас хамгаалах үйл ажиллагааны бодлого стратегийг тодорхойлсон баримт бичгийг батлан хэрэгжүүлж, улс орны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмрээ оруулж ирсэн нь одоог хүртэл даган мөрдөж байна.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх талаар Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна”. Мөн зүйлийн 8.2-т “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах,



Дамдин П. 2017. Хууд. 71.



МОНГОЛ УЛСЫН ХУҮЛЬ
САХИУЛАХҮЙ

хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна”, 8.3-т “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, аргачлалыг онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017)” гэж тус тус заасан.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар “Аймаг, нийслэл, сум, дүүрэг, гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны А/388 дугаар тушаалаар “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үлгэрчилсэн загвар” тус тус батлагдсан.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа гэж гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх,

хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхийг хэлнэ (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017).

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална. Үүнд:

1. хүмүүнлэг, шуурхай, ил тод, хариуцлагатай байх;
2. мэргэжлийн нэгдмэл удирдлагатай байх;
3. шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологи, инновацид тулгуурласан байх;
4. өмчийн хэлбэрийг үл харгалзах;
5. иргэдийн оролцоонд тулгуурлах.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшгийн өмнөх, гамшгийн үе, гамшгийн дараах буюу хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа гэсэн үе шаттай байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шатуудад хэрэгжүүлэх арга хэмжээг Хүснэгт 1-д үзүүллээ.

1. Гамшгийн өмнөх үйл ажиллагаа		
1	Гамшгийн эрсдэлийг үнэлэх	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд нь өмчийн хэлбэрийг үл харгалзан гамшгийн эрсдэлийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийнэ.
	Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах удирдлагын баримт бичиг байна.
	Гамшгийн эрсдэлийг бууруулах	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хуулийн этгээд дараахь арга хэмжээг авна. Үүнд: -болзошгүй гамшгийн шалтгаан, нөхцөлийг арилгах; -барилга байгууламж, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг улс, орон нутгийн төсөвт байгууллага, үйлдвэр, үйлчилгээний байгууллагын аюулгүй байдлын шаардлага, стандартыг хангах; -гамшгийн эрсдэлийг бууруулах бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг хэрэгжүүлэх; -гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх; -хөгжлийн бодлогын төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох.
	Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах	Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна. Үүнд: 1. Өдөр тутмын бэлэн байдал; (гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах; харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, тогтоосон дохиогоор ажиллах арга, ажиллагаанд хүн амыг сургаж дадлагуулах; гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах;



МОНГОЛЫН
Дотоод Ажлын
Төрийн Газар

	гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах; гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний мэдээллийг түгээх; гамшгийн болон орон нутгийн нөөц бүрдүүлэх; гамшгийн үед дайчлан гаргах хүч хэрэгслийн бүртгэл, тооцоог гаргах; салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах;) 2. Өндөржүүлсэн бэлэн байдал; (гамшгийн зарлан мэдээллийн дохиог хүн амд хүргэх, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх, хэрэгжүүлэх; засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх; гамшгийн зарлан мэдээллийг хүн амд шуурхай, хүртээмжтэй хүргэх; хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох, хүч хэрэгсэл, гамшгийн болон орон нутгийн нөөцийг дайчлах; гамшгийн нөөцийг улсын хэмжээнд Засгийн газрын шийдвэрээр, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр нэмэгдүүлэх; соёл урлаг, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахыг хязгаарлах, цуцлах, хориглох; харилцаа холбоо, эрчим хүч, хүнс хангамж, шатахуун түгээх газар болон стратегийн зориулалттайгаас бусад худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, хилийн боомтыг түр хаах, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах; голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, түр орон байр, хүнс тэжээлээр хангах арга хэмжээг зохион байгуулах; нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад чухал үүрэг бүхий хуулийн этгээдэд тусгай дэглэм тогтоож мөрдүүлэх; төрийн болон төрийн өмчит байгууллагын үүрэг, зориулалт, хөдөлмөрийн нөхцөл, ажлын цагийн хуваарийг тогтоосон хугацаагаар өөрчлөх; улсын онц чухал, төрийн тусгай хамгаалалтад байгаа болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллагын хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах; стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллагад чиглэл болгох, хяналт тавих; олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн сүлжээн дэх гамшгийн тухай илт худал мэдээллийн тархалтыг бууруулах, зогсоох арга хэмжээг тухайн нөхцөлийн хэр хэмжээнд тохируулан тодорхой хүрээ, хугацаатайгаар авч хэрэгжүүлэх; эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хэрэгжилтийг хангуулах; гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн үед улсын хил хамгаалах байгууллага холбогдох байгууллагатай хамтран хилийн боомтод тусгай дэглэм тогтоож, мөрдүүлэх; химийн хорт болон аюултай бодис, ачаа тээвэрлэлтийг хязгаарлах, шаардлагатай тохиолдолд түр хугацаагаар зогсоох; зайлшгүй шаардлагатай тохиолдолд иргэн, байгууллага, хуулийн этгээдээс холбогдох мэдээллийг авах бөгөөд тухайн мэдээллийн нууцлалыг хадгалах, түүнчлэн гамшгаас хамгаалахаас бусад зорилгоор урвуулан ашиглахгүй байх;) 3. Бүх нийтийн бэлэн байдал; (дээрх 1,2 заасан арга хэмжээг бүхэлд нь хэрэгжүүлнэ.)
Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх	Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний



ᠭᠠᠮᠤᠰᠢᠭ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

		хэрэгжилтэд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина.
	Гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах	Гамшгаас хамгаалах сургалт нь төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтан болон иргэнийг сургаж дадлагдажуулахад чиглэнэ. Гамшгаас хамгаалах сургалтыг дараахь ангиллаар явуулна. Үүнд: 1. Удирдах албан тушаалтны; 2. Онцгой байдлын байгууллагын; 3. Оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн; 4. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны; 5. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн; 6. Иргэний.
	Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх	Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын дүн мэдээг нэгтгэх, статистикийн мэдээллийг боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээ хийх, үр дүн, санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа ашиглах, мэдээлэх, нийтийн хүртээл болгох, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ. Гамшгийн мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ. Үүнд: 1. Гамшгийн эрсдэлтэй нутаг дэвсгэрийн газар зүйн мэдээлэл; 2. Гамшигт нэрвэгдэж болзошгүй хүн ам, дэд бүтцийн бүртгэл, мэдээлэл; 3. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын болон хохирлын дүн мэдээ; 4. Бусад мэдээлэл.
2. Гамшгийн үеийн үйл ажиллагаа		
2	Гамшгийн харилцаа холбоо, зарлан мэдээллийг зохион байгуулах	Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлэг, гамшгийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг мэдээлэх зорилгоор зарлан мэдээллийг шуурхай зохион байгуулна. Гамшиг болон аюулын тухай мэдээ, мэдээллийг цуглуулах, холбогдох шийдвэрийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хүргэх, түүнчлэн улс хооронд харилцан мэдээлэл солилцоход харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглана. Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй. Голомтын бүсэд үүрэг гүйцэтгэж байгаа шуурхай бүлэгтэй холбоо зохион байгуулах, мэдээлэл солилцох ажиллагааг онцгой байдлын болон төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага гүйцэтгэнэ.
	Голомтын бүс тогтоох	Аймаг, сум, нийслэл, дүүргийн нутаг дэвсгэр, объектод хор уршгийг арилгах арга хэмжээг шууд удирдан зохион байгуулж байгаа мэргэжлийн байгууллагын удирдлага, эсхүл мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн тухайн шатны Засаг дарга; хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэр болон улсын онц чухал объектод онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. Голомтын бүсэд хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тухайн шатны онцгой байдлын байгууллага удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавина.
	Эрэн хайх, аврах	Эрэн хайх, аврах ажиллагааг томилгоот шуурхай бүлэг гүйцэтгэнэ. Шуурхай бүлгийн удирдагч онцгой байдлын байгууллагын алба хаагч байх ба эрэн хайх, аврах ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэй. Эрэн хайх, аврах ажиллагаанд оролцож байгаа сайн дурын хэсэг, иргэн шуурхай бүлгийн удирдагчийн зааврын дагуу үүрэг гүйцэтгэнэ. Нэрвэгдэгсдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээг эмнэлгийн



		байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай үзүүлэх үүрэгтэй.
	Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед шаардлагатай тохиолдолд хүч хэрэгслийг дайчлан гаргаж, хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, музейн үзмэр, цуглуулга, түүх, соёлын дурсгалт зүйлийг аюулгүй газарт нүүлгэн шилжүүлнэ. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж нь хүн амыг нүүлгэн шилжүүлэх талбай, байршуулах байр, байгууллага, хуулийн этгээд нь түр цугларах аюулгүйн талбайтай байна.
	Гамшгийн хор уршгийг арилгах	Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өөрөө, эсхүл үүссэн нөхцөл байдлыг харгалзан Онцгой байдлын байгууллага мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.
2. Гамшгийн дараах буюу хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа		
3	Нийгмийн амьдралыг хэвийн нөхцөлд оруулах;	Нөхөн сэргээх, урт хугацааны болон түр зуурын арга хэмжээ авах, ахуйн үйлчилгээ болон орон сууцаар хангах явдал юм.
	Дэд бүтцийг сэргээн босгох.	Сэргээн босголт нь гамшигт нэрвэгдэгсдийг гамшгийн өмнөх хэвийн нөхцөл оруулах оролдлого юм. Барилга байгууламж, дэд бүтцийг сэргээн босгох урт хугацааны хөгжлийн төлвийг хэлнэ. Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дотоодын болон гадаад улсын, эсхүл олон улсын байгууллага, хуулийн этгээд, иргэдийн хүмүүнлэгийн тусламжийг авч болно.

Хүснэгт 1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үе шатуудад хэрэгжүүлэх арга хэмжээ

Манай улсын хувьд Гамшгаас хамгаалах тухай хуульд зааснаар улсын хэмжээнд гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд орон нутгийн зөвлөл ажиллаж, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн болон салбар дундын хамтын ажиллагаа, иргэдийн оролцоог хангах, бодлогын зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2017).

Гэхдээ үндэсний болон орон нутгийн зөвлөл нь дөнгөж шинэ түвшинд ажиллаж байгаа тул олон улсын туршлага, сургамжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Өнөөдрийн байдлаар хэрэгжүүлэн мөрдлөг болгож байгаа Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах бүтцийг авч үзвэл гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь 6 бүлгээс бүрдэнэ (Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, 2013). Үүнд:

- *Нэгдүгээр бүлэг.* Нийтлэг үндэслэл;

- *Хоёрдугаар бүлэг.* Танилцуулга;

- *Гуравдугаар бүлэг.* Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө;

- *Дөрөвдүгээр бүлэг.* Хариу арга хэмжээний төлөвлөгөө /аюулт үзэгдлийн төрөл бүрээр/;

• Эрэн хайх, хор уршгийг арилгах төлөвлөгөө;

• Гамшгаас хамгаалах дайчилгаа зохион байгуулах төлөвлөгөө;

• Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө;

Тавдугаар бүлэг. Сэргээн босгох төлөвлөгөө;

Зургадугаар бүлэг. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах төлөвлөгөө;

- *Хавсралт /захирамжлалын баримт бичгийн төсөл, зарлан мэдээллийн схем, хүч хэрэгслийн тооцоо судалгаа, нөөц, хангамж, байр зүйн болон план зураг гэх мэт/ бүтэцтэй байна.*



ᠮᠣᠩᠭᠣᠯᠤ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ

Нийслэл Улаанбаатар хотын газар
хөдлөлтийн гамшгаас хамгаалах
төлөвлөгөөг хавсралт-1-д үзүүлээ.

Олон улсын туршлагад хийсэн судалгаа:

д/д	Гадаад орны нэр	Хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, туршлага
1	ОХУ	ОХУ-ын Ерөнхийлөгчийн эрх бүхий төлөөлөгчидтэй, Засгийн газар болон холбооны гүйцэтгэх байгууллагуудын харилцан ажиллагааг тодорхойлж “ОХУ-ын далай, тэнгис, усан байгууламжид тохиолдсон гамшгийн үед эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах үеийн улсын албадын харилцан ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан байдаг юм. Мөн ОХУ-ын Ерөнхийлөгчийн 2005 онд зарлигаар "ОХУ-д тохиолдсон гамшгийн үед төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг зохицуулах харилцан ажиллагаа" гэсэн удирдлагын баримт бичиг гаргасан байна. Энэхүү баримт бичгээр ОХУ-ын Дотоод хэргийн яам, Онцгой байдлын яам, Хууль зүйн яам, бусад холбооны яам болон гүйцэтгэх байгууллагын харилцан ажиллагааны зохицуулалтыг зохион байгуулдаг бөгөөд мөн тухайн үед хэн удирдах, хэн гүйцэтгэх, хэн дэмжлэг үзүүлэх гэх мэт бүх асуудлыг тусгасан байдаг.
2	БНХАУ	Хятад улс нь олон төрлийн байгалийн аюулт үзэгдэлд өртөмтгий бөгөөд үүнд үер, ган, хөрсний гулсалт, шуурга, газар хөдлөлт ордог. Уур амьсгалын дулаарал болон улс орны хурдтай үйлдвэржилт, хотжилтоос шалтгаалан иргэдийн байгалийн аюулт үзэгдэлд өртөх эмзэг байдал нэмэгдсээр байна. Тус улсад жил бүр дунджаар 300 сая хүн гамшигт өртөж, 4 сая хүнийг гамшгийн улмаас нүүлгэн шилжүүлдэг байна. Эдүгээ гамшгийн улмаас учирч буй хохирлын хэмжээ өнгөрсөн 30 жилтэй харьцуулахад 40 хувиар өссөн нь тус улсын тогтвортой хөгжилд ноцтой заналхийлж байгаа юм. Байгалийн гамшгийн аюулыг бууруулах зорилгоор Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хороог шинээр байгуулан тус хороо нь гамшгийн эрсдэл бууруулах асуудлыг сурталчлах болон хөгжлийн төлөвлөлт ба үйл явцад тусгах арга хэмжээг хэрэгжүүлдэг байна¹. Дээрх байгууллага нь хамгийн их заналхийлж буй аюулт үзэгдлүүдтэй холбоотой гамшгийн эрсдэлийн тухай мэдээллийг цуглуулж, нэгтгэж, судалж, үнэлэх чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлж, Иргэний хэрэг, Усны нөөц, Газрын нөөц болон хөдөө аж ахуй хариуцсан яамд, мөн статистик, цаг уур, газар хөдлөлтийн асуудал хариуцсан товчоод гамшигтай холбоотой үндэсний хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, гамшгийн үед хэрэгжүүлэх хамтарсан бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж, хариу арга хэмжээ зохицуулах механизмыг зохион байгуулдаг байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор эрт зарлан мэдээлэл, хариу арга хэмжээ, гамшгийн менежментэд сансрын технологийг ашиглаж, гамшгийн дараах яаралтай тусламж, сэргээн босголтыг шуурхай зохион байгуулах зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлж байна. Мөн гамшигтай хамгийн үр ашигтай аргаар тэмцэхийн тулд ялангуяа хөрш орнуудад адил төрлийн эрсдэл заналхийлж байгаа тохиолдол, эрсдэл бууруулах бүсийн хамтын ажиллагааг чухалчилж байна.



Дэвшилтийн Хөгжлийн Газар

3	Япон улс	Япон улсад гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд тэдний хоорондын харилцан ажиллагааг гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө маш нарийн тусгасан байдаг байна. Энэхүү харилцан ажиллагааны асуудлыг Гамшгаас хамгаалах Үндэсний зөвлөл хариуцан ажилладаг бөгөөд мөн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хариуцан боловсруулах ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг хангуулдаг байна. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг нарийн боловсруулж хэрэгжүүлдэг бөгөөд тус улс өөрийн онцлогт тохируулан газар хөдлөлтийн гамшгийн үед ажиллахад төлөвлөгөөг маш нарийн зохион байгуулалттайгаар боловсруулж мөрдүүлдэг байна. Тус улсын Гамшгаас хамгаалах Үндэсний зөвлөл гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа бүх талын төлөөллийг оролцуулан тэдний гүйцэтгэх үүргийг тодорхойлж түүгээр дамжуулан харилцан ажиллагааг яаж зохион байгуулахыг тодорхойлж өгдөг байна. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний зарчим нь болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан төлөвлөгдсөн, шуурхай, уян хатан, тасралтгүй байх, хязгаарлагдмал нөөцийг үр дүнтэй ашиглах “хийж гүйцэтгэх ажил”, “хэрэгжүүлэх арга зам”, “хугацаа”, “хариуцах эзэн /хүн/”, “хамтран хэрэгжүүлэх байгууллага /алба/”, “шаардагдах зардал” гэсэн асуумжид хариулагдахаар, “удирдлага, зохион байгуулалт,” “гамшгаас урьдчилан сэргийлэх”, “аврах”, “хор уршгийг арилгах”, “сэргээн босгох ажиллагаа” гэсэн үе шатаар төлөвлөгдсөн байдаг бөгөөд эдгээр асуудлаас харахад харилцан ажиллагааг давхар тооцон боловсруулдаг байна.
---	----------	---

Хүснэгт 2. Олон улсын гамшгаас хамгаалах үйл ажиллагаа, төлөвлөлт

Дээрх олон улсын туршлагыг харьцуулан судлахад Онцгой байдлын байгууллага ба тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага, гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албад, төв орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын харилцан ажиллагаа түүнд оролцогчдын түвшин, бүрэлдэхүүний байдлаас хамаарч стратегийн, оперативын, тактикийн гэж хуваан үзэж болж байна.

Менежментийн ухааны үүднээс удирдлага зохион байгуулалтыг дээд, дунд, доод удирдлага нь дээрх харилцан

ажиллагааны түвшинтэй уялдаж байна. Иймд хариу арга хэмжээ, харилцан ажиллагааны төлөвлөлтийг боловсруулахад гамшгаас хамгаалах сургалтыг оруулах зайлшгүй шаардлага бий болж байна.

Судалгааны үр дүн. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний өнөөгийн байдалд SWOT шинжилгээ хийж дотоод хүчин зүйл буюу давуу болон сул тал, гадаад хүчин зүйл буюу боломж болон таатай нөхцөл, аюул буюу таагүй нөхцөл байдлыг тодорхойлсон.

Давуу тал:	Сул тал:
Гамшгаас хамгаалах тухай хууль, эрх зүйн зохицуулалт бүрдсэн; Улс, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд Онцгой комисс, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл ажиллах, гамшгаас хамгаалах тогтолцооны бүтэц бүрдсэн;	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, үнэлэх тогтолцоо сул; Гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах төлөвлөлтөд төсөв хязгаарлагдмал тул төлөвлөсөн үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэй; Зарим аймаг, сумдад техник, тоног төхөөрөмж дутагдалтай, хариу арга хэмжээ авах чадамж сул; Олон нийтэд зохион байгуулж байгаа гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийн талаарх



ᠮᠤᠩᠭᠣᠯᠤ ᠰᠤᠵᠤᠨ ᠰᠤᠵᠤᠨ ᠰᠤᠵᠤᠨ

Хүний нөөцийн хувьд мэргэшсэн аврагч, гал сөнөөгчид, ажилтан, алба хаагч, сайн дурынхан ажиллаж байна; Гамшгаас хамгаалах чиглэлээр олон нийтийн сургалт, нөлөөллийн аян нэмэгдэж, иргэдийн мэдлэг дээшилж байна; Мэдээлэл технологийн чиглэлээр сэрэмжлүүлгийн ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэхээр туршиж эхэлсэн; Олон улсын хамтын ажиллагаатай байгууллага болох Дэлхийн эрүүл мэдийн байгууллага, Дэлхийн зөн олон улсын байгууллагуудтай хамтран гамшгаас хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байна.	нэгдсэн дадлага сургуулийн хугацаа нь урт, мэргэжлийн боловсон хүчин дутмаг, сургах тогтолцоо сул; Аюулт үзэгдэл, ослын үед байгууллага хоорондын мэдээлэл солилцох, уялдаа холбоо дутмаг, хамтран ажиллах механизм сул; Зарим байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө хуучирсан, шинэчлэгдээгүй, бодит нөхцөл байдалтай нийцдэггүй.
Боломж:	Аюул:
Олон улсын туршлага сургамжид суурилсан төлөвлөлт хийх боломжтой; Гамшгаас хамгаалах төлөвлөлтөд Олон улсын хяналт, үнэлгээний сайн туршлагыг нэвтрүүлэх; Ухаалаг шинэлэг технологи ашиглах энэ нь газарзүйн мэдээллийн систем /GIS/, хиймэл дагуулын зураглал, гар утасны апп, эрт сэрэмжлүүлгийн систем ашиглах боломжтой; Олон нийтэд мэдлэг олгох зорилгоор сургуулийн насны хүүхдүүд, залуучуудыг гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэлийг ойлгох боловсролд хамруулах боломж шаардлагатай байна; Гамшгийн эрсдэлийг бууруулахад хувийн хэвшлийн байгууллагатай түншлэл байгуулан хамтран ажиллаж, хөрөнгө, нөөц, логиستيкийг нэмэгдүүлэх боломжтой; Олон улсын байгууллагатай хамтын ажиллагаа байгуулан санхүүжилт нэмэгдүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлэн ажиллах боломжтой;	Сүүлийн жилүүдэд газар хөдлөлтийн давтамж нэмэгдэж байгаа нь аюул дагуулж байна; Улаанбаатар хотын төвлөрөл нэмэгдэж байгаа өнөө үед гамшгийн эрсдэл, аюул өндөр байна; Төлөвлөлтгүй барилгажилт нь газар хөдлөлт, үер зэрэг гамшигт өртөмтгий байдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй; Инженерийн дэд бүтэц хуучирсан нь газар хөдлөлтийн гамшгийн үед гэмтэхэд систем бүхэлдээ доголдож, гамшгийн дараах сэргээн босгох ажиллагаа удаашрах аюултай; Гамшгийн үед төрийн байгууллагуудын удирдлага, зохицуулалт давхардал болон зөрчил үүсэх магадлалтай;

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний өнөөгийн байдалд SWOT шинжилгээнээс үзэхэд гамшгаас хамгаалах тухай хууль, эрх зүйн зохицуулалт бүрдсэн, улс, аймаг, нийслэл, дүүргийн түвшинд Онцгой комисс, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл ажиллах, гамшгаас хамгаалах тогтолцооны бүтэц бүрдсэн, хүний нөөцийн хувьд мэргэшсэн аврагч, гал сөнөөгчид, ажилтан, алба хаагч, сайн дурынхан ажилладаг, гамшгаас хамгаалах чиглэлээр олон нийтийн сургалт, нөлөөллийн аян нэмэгдэж, иргэдийн мэдлэг, мэдээлэл технологийн чиглэлээр

сэрэмжлүүлгийн ухаалаг шийдлүүдийг нэвтрүүлэхээр туршиж эхэлснээс гадна олон улсын хамтын ажиллагаатай байгууллага болох Дэлхийн эрүүл мэдийн байгууллага, Дэлхийн зөн олон улсын байгууллагуудтай хамтран гамшгаас хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг нь давуу талтай байна.

Зарим төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын гамшгийн үеийн харилцан ажиллагааны төлөвлөгөө нь нууцийн зэрэглэлтэй, мэргэжлийн болон мэргэшүүлэх сургуулиуд тогтмол хийгдээгүй, томилогдсон бүлгүүдийн хоорондын хамтын ажиллагаа бүрэлдээгүй, аюулт үзэгдэл, ослын үед байгууллага хоорондын мэдээлэл солилцох, уялдаа

холбоо дутмаг, хамтран ажиллах механизм сул, гамшгийн гүйцэтгэх үүрэг тус бүрээр нарийвчлан тодотгож, сургалт, дадлагыг зохион байгуулж байгаагүй зэрэг сул талтай.

Боломжийг ашиглаж сул талаа арилгах, давуу талаараа аюулаас зайлсхийх, сул тал, аюул заналыг хоёулыг нь бууруулах боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ сэдвийн хүрээнд төлөвлөлтийн онол арга зүйн асуудал, гамшгаас хамгаалах төлөвлөлтийн тухай ойлголт, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төлөвлөлтийг хэрхэн хийх, гамшгаас хамгаалах төлөвлөлтийн талаарх зарим улс орны туршлага түүнд үндэслэн өнөөгийн байдалд шинжилгээ хийж, гамшгаас хамгаалах төлөвлөлтийг сайжруулах арга замыг дэвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг зайлшгүй судлах шаардлага тулгарч байна.

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хийх хамгийн оновчтой арга хэлбэр бол бүх түвшинд боловсруулах явдал юм. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний цар хүрээ хүн амын хэрэгцээ болон тухайн гамшгийн эрсдэлээс хамааран олон янз байхын зэрэгцээ эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагааны үед үүсэх маш олон төрлийн хэрэгцээг хангахуйцаар хийгдэх шаардлагатай бөгөөд төлөвлөгөөг боловсруулах ажлыг хамтран хэрэгжүүлэх гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн төлөөллийг оролцуулах бөгөөд эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөгөөг боловсруулах нь зүйтэй гэж дүгнэж байна.

Санал

Мөн илтгэлдээ гамшгаас хамгаалах төлөвлөгөөний өнөөгийн байдалд шинжилгээ хийж, судалж үзэхэд дараах саналыг тусгалаа. Үүнд:

- Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөөг Олон улсын туршлага сургамжид тулгуурлан боловсруулж, бүрэн хэрэгжүүлэх;

- Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт, арга хэмжээ, хэрэгжүүлэх байгууллага, шаардагдах төсөв хөрөнгийн мэдээллийг гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодорхой тусгаж оруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн асуудлыг цаг бүрд нь шийдвэрлэх;

- Гамшгийн үед хоргодох түр байрнуудын тэсвэржилтийг нэмэгдүүлэн хүчитгэж, гамшгийн үед хэрэглэх шаардлагатай дулаан хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, материал, хоол хүнсний хангалтыг бэлэн байлгах;

- Иргэдэд гамшгийн болон зарлан мэдээллийн төхөөрөмж, дуут цамхгийн бэлэн байдлыг хангаж, байгууламжийг хүчитгэх, дохио өгөх, зарлан мэдээлэл дамжуулах төхөөрөмжийг нэмж суурилуулах, байнга сайжруулж байх.

Ном зүй

Дамдин П. (2017). *Монгол Улсын Иргэний хамгаалалтын түүхэн замнал*. Улаанбаатар: ОБЕГ.

Цэдэв П. (2018). *Гамшгаас хамгаалах төлөвлөлт*. Улаанбаатар: ДХИС.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2013 оны 06 11). ОБЕГ-ын даргын 2013 оны 6 дугаар сарын 11 өдрийн А/170 тушаал. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загвар”-ыг нэгдүгээр, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар”-ыг хоёрдугаар хавсралт. Улаанбаатар, Улаанбаатар, Монгол: ОБЕГ.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. (2017 оны 02 02). Гамшгаас хамгаалах тухай хууль. *Төрийн мэдээлэл*, 07. <https://legalinfo.mn/mn>



УЛААНБААТАР ХОТЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС
ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ



ᠬᠠᠮᠤᠰᠢᠭ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Удирдан зохицуулах байгууллага	Дэмжлэг үзүүлэх байгууллага
Нэг. Удирдлага, зохион байгуулалт				
1.1	Нийслэлд үүссэн газар хөдлөлтийн гамшгийн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг шууд эхлүүлж, бүх төрлийн холбооны хэрэгслийн тогтворжилтыг шалгаж, нөхцөл байдлыг удирдлагад мэдээлэх	Ц+20 минут	НОБГ, “УБШУЗТ” ОНӨТҮГ	НЦХМТГ
1.2	Гамшгийн цагийн байдал үүссэн нөхцөлд холбооны сувгийн найдвартай ажиллагааг шалгаж, ажиллагаанд оруулж, мэдээ мэдээллийг шуурхай дамжуулах	Ц+30 минут	НОБГ, “УБШУЗТ” ОНӨТҮГ	НЦХМТГ
1.3	Газар хөдлөлтийн гамшгийн үед үүссэн цагийн байдлын талаар нийслэлийн Онцгой комиссоос мэдээлэл хийх	Ц+2 цаг	НЗДТГ-ын ХМОНХХ	НОБГ
1.4	Нийслэлийн нөөц удирдлагын ажлын байрыг гаргаж, шуурхай штабын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, удирдлага зохион байгуулалтаар хангах	Ц+3 цаг	НОБГ	НЗДТГ-ын Цэргийн штаб
Хоёр. Хариу арга хэмжээ				
2.1	Газар хөдлөлтийн гамшиг болсон тохиолдолд Онцгой комиссын гишүүд, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн, хүч хэрэгсэлтэй зарлан мэдээллийн дохио хүлээхгүйгээр ажлын байрандаа цугларах	Ц+1 цаг 30 минут	Нутгийн захиргааны байгууллагууд	НОБГ
2.2	Нийслэлийн Аврах ангийн бэлтгэл ээлж, Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүн Төрийн ордны томилгоот хэсгүүдэд аврах үйл ажиллагаа эхлүүлэх	Ц+1 цаг	НОБГ	ЧДОБХ
2.3	Нийслэлийн Аврах анги, Гал түймэр унтраах, аврах 34 дүгээр ангийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүн нийслэлийн Засаг даргын Тамгын газрын байранд аврах үйл ажиллагаа явуулах	Ц+1 цаг	НОБГ	НЗДТГ
2.4	Нийслэлийн хэмжээнд Төрийн 26, хувийн 101 эмнэлгийн барилга байгууламжаас газар хөдлөлтийн гамшигт нураагүй үлдсэн эмнэлгүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тасралтгүй үзүүлэх ажлыг зохион байгуулах	Ц+3 цаг	НЭМГ	Дүүргүүдийн ЭМТ
2.5	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1511 дүгээр захирамжаар томилгоожсон 344 байгууллагын барилга байгууламжаас газар хөдлөлтийн гамшигт нураагүй үлдсэн обьектод орон гэргүй болсон иргэдийг байршуулах ажлыг зохион байгуулах	Ц+5 цаг	НХБХГ, ННТГ	НОБГ
2.6	Газар хөдлөлтийн үед гамшгийн голомтуудад хэв журам сахиулах, материал баялгийг хамгаалалтад авах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах	Ц+2 цаг	НЦУГ	ТЦА-ны ЗЦГ
2.7	Газар хөдлөлтийн улмаас Орон сууцны контуруудын аваарын техникийн бүлгүүд цаашид ашиглагдах боломжтой байруудын	Ц+1 цаг 30 минут	“ОСНААГ” ОНӨААТҮГ	“Дулааны сүлжээ” ТӨХК

	дулааны системүүдийг хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах			
2.8	Газар хөдлөлтийн улмаас цахилгааны аваарын техникийн бүлгүүд нэн шаардлагатай байгууллага болон 1-р зэргийн хэрэглэгчийг цахилгаанаар хангах ажлыг зохион байгуулах	Ц+3 цаг	“Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК	“ОСНААГ” ОНӨААТҮГ
2.9	Газар хөдлөлтийн улмаас нийслэлийн усан хангамжийн системд үүссэн хохирлын тооцоо гаргаж, эхний ээлжид хэрэглээний цэвэр усаар шаардлагатай нэгжүүдийг хангах арга хэмжээ авах	Ц+5 цаг	“УБУСУГ” ОНӨААТҮГ	“ОСНААГ” ОНӨААТҮГ
2.10	Газар хөдлөлтийн гамшгийн улмаас цацраг, химийн хорт бодис алдагдсан үед хор уршгийг арилгах арга хэмжээ авах	Ц+2 цаг	НОБГ	НЦУГ
2.11	Нефтийн агуулах, патахуун түгээх станц, шингэрүүлсэн шатдаг хий аж ахуйн нэгж байгууллагуудын аюулгүй байдлыг хангах, гарсан гал түймрийг шуурхай унтраах	Ц+30 минут	НОБГ	ТЦА-ны ЗЦГ
2.12	Тандалтын бүлгүүдийг гаргаж, гамшгийн голомтын заагийг тодорхойлох	Ц+6 цаг	НОБГ	НЦУГ
2.13	Газар хөдлөлтийн гамшгийн голомтод аврах үйл ажиллагааг явуулах үеийн шаардлагатай хүнд машин механизм, багаж хэрэгслийг дайчлах ажлыг зохион байгуулах	Ц+8 цаг	НЗДТГ, УБЗАА	НОБГ
2.14	Газар хөдлөлтийн үед нэрвэгдэгсдийг түр байрлуулах орон байр, дулаан хувцас, хоол хүнс, цэвэр усаар хангаж, эмнэлгийн тусламж үзүүлэх ажлыг дүүргүүд төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	Ц+5 цаг	Дүүргүүдийн ЗДТГ	УБЗАА
2.15	Газар хөдлөлтийн гамшгийн голомт нь их хэмжээний талбайг хамарч, иргэдийг зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлага гарсан тохиолдолд 31 байршилд нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах	Ц+10 цаг	НЗДТГ-ын Цэргийн штаб, ТЦА-ны ЗЦГ, ННТГ, НЦУГ	НГЗБА
2.16	Газар хөдлөлтийн улмаас буцалтгүй нэрвэгдэгсдийг таниулах, оршуулах ажлыг онцгой комиссын шийдвэрээр зохион байгуулах	Ц+24 цаг	НЦУГ, НЭМГ	НОБГ



Дотоод Ажлын Яаман